**МОНГОЛ УЛСЫН**
**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН**
**ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2014.04.15 № 01/1446

танай ____________-ны №_____________-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тус яамнаас гаргах мэдээ, мэдээллийг хуваарийн дагуу хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
СТРАТЕГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Л.ЧОЙ-ИШ

00001303

## ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН 2014 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХИЙГДЭЖ БУЙ АЖЛЫН ЯВЦ

| дугаар | төсөл, арга хэмжээ | хугацаа | | төсөвт өртөг | 2014 онд санхүүжих | Зохион байгуулах газар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эхлэх | дуусах | | | | |
| XXI | ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД | | | **55,061.6** | **41,561.6** | | |
| **XXI.1** | **I.Хөрөнгө оруулалт** | | | **45,661.0** | **32,161.0** | | |
| | Шилжих | | | 12,271.0 | 6,771.0 | | |
| XXI.1.1 | Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор сум/ | 2012 | 2016 | 12,271.0 | 6,771.0 | | 2013 онд тендер зарлагдан гэрээ байгуулагдсан. Хуваарийн дагуу санхүүжилт хийгдэж, ажил үргэлжиж байна. |
| XXI.1.2 | Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 2012 | 2014 | - | - | | Үндэсний аудитын газраас лабораторын ажлыг үргэлжлүүлэх дүгнэлт ирүүлсэн. |
| XXI.1.3 | Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын төв /Хан-Уул дүүрэг/ | 2012 | 2014 | - | - | | Үндэсний аудитын газраас хасах дүгнэлт ирүүлсэн. |
| XXI.1.4 | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд/ | 2013 | 2014 | - | - | | Үндэсний аудитын газраас цэвэрлэх байгууламжийн ажлыг хойшлуулах дүгнэлт ирүүлсэн. |
| XXI.1.5 | Хөнгөн үйлдвэрийн салбарт нано биотехнологи нутагшуулах | 2012 | 2014 | - | - | | Үндэсний аудитын газраас ажлыг хойшлуулах дүгнэлт ирүүлсэн. |
| | Шинэ | | | 33,390.0 | 25,390.0 | | |
| XXI.1.6 | Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа" төслийн Монголын талын хөрөнгө | 2014 | 2014 | 100.0 | 100.0 | ҮХААЯам | 2014.03.27-ны өдөр "Монтегео ХХК"-тай гэрээ байгуулсан. |
| XXI.1.7 | Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Бүх аймагт/ | 2014 | 2014 | 10,000.0 | 10,000.0 | | 21 аймаг, нийслэлд 410 ширхэг худаг хувиарласан бөгөөд орон нутагт худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг.2014.02.19-ны өдрийн А/26 дугаар тушаалаар Орон нутагт зохион байгуулах эрх шилжүүлсэн. |
| XXI.1.8 | Төрийн болон орон нутгийн өмчлөлийн тариалангийн талбайн услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих, ус хуримтлуулах сан бүхий боомтын барилга /Тариалангийн бүс нутагт/ | 2014 | 2014 | 3,000.0 | 3,000.0 | ХААГазар | 2014.03.10-ны өдөр тендерийг зарласан. 2014.04.10-ны өдөр хүлээж авна. |
| XXI.1.9 | Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул/ | 2014 | 2015 | 16,000.0 | 8,000.0 | ҮХААЯам | 36,0-54,0 мянган тонны багтаамжтай элеватор худалдан авахаар төлөвлөн 2014.02.26-ны өдөр тендерийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгэр зарласан. 2014.03.28-ны өдөр хүлээж авсан.Үнэлгээ хийх шатандаа байна. |
| XXI.1.10 | Хэрлэнбаян-Улаан, Чилэн, Багахайрханы аймаг дундын отрын бүс нутагт богийн чулуун хороо барих | 2014 | 2014 | 300.0 | 300.0 | ХААГазар | 2014.03.13-ны өдөр тендерийг зарласан. 2014.04.14-ны өдөр хүлээж авна. |
| XXI.1.11 | Өвс, тэжээлийн нөөцийг хадгалах агуулах /Аймаг дундын отрын бүс нутаг/ | 2014 | 2014 | 750.0 | 750.0 | ХААГазар | 2014.04.02-ны өдөр тендерийг зарласан. 2014.05.02-ны өдөр хүлээж авна. |
| XXI.1.12 | Чилэнгийн отрын бүс нутгийг хашаажуулж, хамгаалах /Булган, Дашинчилэн сум/ | 2014 | 2014 | 240.0 | 240.0 | | 2012 онд хийгдсэн ажлын санхүүжилт олгогдсон. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| XXI.1.13 | Хүлэмж, зоорийн аж ахуй байгуулах /Сэлэнгэ, Мандал сум/ | 2014 | 2014 | 3,000.0 | 3,000.0 | ХААГазар | Хүлэмж, зоорийн аж ахуйн цогцолбор байгуулахаар төлөвлөсөн бөгөөд хүлэмж, зоорийн аж ахуйн зураг төсвийг ХААГазарт хүргүүлсэн тендер зарлах шатандаа байна. |
| **XXI.2** | **II.Их засвар** | | | **816.0** | **816.0** | | |
| | Шинэ | | | 816.0 | 816.0 | | |
| XXI.2.1 | "Биокомбинат" Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадна инженерийн шугам сүлжээний шинэчлэлийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 2014 | 2014 | 816.0 | 816.0 | ХААГазар | Зураг төсөл, төсөв нь хийгдсэн бэлэн байгаа бөгөөд ХААГазраас зураг төсвийг хянан баталгаажуул гэсэн үүрэг өгсний дагуу холбогдох газарт нь хүргүүлсэн. |
| **XXI.3** | **III.Тоног төхөөрөмж** | | | **1,184.6** | **1,184.6** | | |
| | Шинэ | | | 1,184.6 | 1,184.6 | | |
| XXI.3.1 | Малын эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн чадавхийг сайжруулах багаж, тоног төхөөрөмжөөр хангах | 2014 | 2014 | 184.6 | 184.6 | ХААГазар | 2014.04.03-ны өдөр Тендерийн үнэлгээний хороо тендерт үнэлгээ хийж ТБОНӨХБАУХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтын дагуу тус тендерээс татгалзах дүгнэлт гаргаж, 30.4.1 дахь заалтын дагуу дахин зарлахаар болсон. |
| XXI.3.2 | Харьяа байгууллага, мал эмнэлгийн яаралтай тусламжийн техник шинэчлэл | 2014 | 2014 | 1,000.0 | 1,000.0 | ҮХААЯам | 2014.03.06-ны өдөр тендерийг зарласан. 2014.04.07-ны өдөр хүлээж авна. |
| **XXI.5** | **V.Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг** | | | **7,400.0** | **7,400.0** | | |
| | Шинэ | | | 7,400.0 | 7,400.0 | | |
| XXI.5.1 | Мал эрүүлжүүлэх туулгалт, угаалгын ванн /Орон нутагт/ | 2014 | 2014 | 3,000.0 | 3,000.0 | ҮХААЯам | 2014.03.31-ний өдөр Тендерийн үнэлгээний хороо тендерт үнэлгээ хийж ТБОНӨХБАУХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу тус тендерээс татгалзах дүгнэлт гаргаж, 30.4.1 дахь заалтын дагуу дахин зарлахаар болсон. |
| XXI.5.2 | Зөгийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх /Орон нутагт/ | 2014 | 2014 | 1,400.0 | 1,400.0 | ҮХААЯам | Зөгийн үүр, эх зөгий, зөгийн бүл, лабортори йн тоног төхөөрөмж худалдан авахаар тендерийг 2014.03.11-нд тендерийг зарласан. 2014.04.11-ний өдөр хүлээж авна. |
| XXI.5.3 | Малын тэжээлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /Эрчимжсэн мал аж ахуй эрхлэж буй аймаг, сум, хот суурин газрууд/ | 2014 | 2014 | 3,000.0 | 3,000.0 | ҮХААЯам | 2014.03.11-ны өдөр тендерийг зарласан. 2014.04.11-ний өдөр хүлээж авна. |

## МАХНЫ ХАНГАМЖ, НӨӨЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭ

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2014 оны хэрэгцээнд зориулан 14 мян.тн махны нөөц бэлтгэж, нийт 77.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Үүний 20%-ийг Арилжааны банкны өөрийн эх үүсвэрээс, 80%-ийг Монголбанкны эх үүсвэрээс гаргасан.

Нөөцийн махны худалдааг 2013 оны 12-р сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2014 оны 4-р сарын 06-ны өдрийн байдлаар 2,280.9 тн (нийт бэлтгэсэн махны 16.2%) мах борлуулж, банкны хуваарийн дагуу 9.9 тэрбум төгрөгийн зээлийг буцаан төлөөд байна.

Нөөцийн махны худалдаагаар Улаанбаатар хотод сүүлийн 2 долоо хоногийн дунджаар хоногт 60 тн мах худалдан борлуулж байгаа нь хотын хүн амын хоногийн хэрэгцээний 30%-ийг хангаж байна.

Хэдийгээр нөөцөлсөн мах Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 1 сараас 7-н сар хүртэлх махны хэрэгцээний зөвхөн 30 гаруй хувийг хангаж байгаа боловч шинэлэг арга барилаар ажиллаж, хяналтыг олон талаас нь тавьсны үр дүнд:

- Хонины ястай махны үнийн өсөлт нь 2014 оны 3 дугаар сарыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,3%-ийн бууралттай байна.
- Үхрийн ястай махны үнийн өсөлт нь өнгөрсөн оны 3 дугаар сарыг 2012 оны мөн үетэй харьцуулахад 12,3%-ийн өсөлттэй байсан бол, энэ оны 3-р сарын үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,1%-ийн өсөлттэй байна. Энэ нь үхрийн ястай махны үнийн өсөлтийн эрчим нь өнгөрсөн оноос 5,8 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Тус дэд хөтөлбөрийн хүрээнд агуулахын үлдэгдэл, хөдлөх хөрөнгийг барьцаалан зээл олгож эхэлсэнээр зах зээлийн механизмд суурилсан байнгын тогтолцоо бүхий шинэ хэрэгсэл бий болох, цаашид Засгийн газар болон Монголбанкны оролцоогүйгээр махны нөөц бэлтгэлийн ажил үргэлжлэх боломж бүрдэж байна.

**Улаанбаатар хотын махны дундаж үнийн харьцуулалт**

2014.04.09

| Махны нэр төрөл | 2014 оны үзүүлэлт, төгрөг | | | | | 2014 оны 7 хоногийн дундаж үнэ, төгрөг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 сар | 2 сар | 3 сар | 2014.02 сар дундаж/2014.03 сар | | 3 сарын 2-р | 3 сарын 3-р | 3 сарын 4-р | 4 сарын 1-р | 4 сарын 2-р | 4 сар 1-р/4 сар 2-р | |
| | | | | Төг | % | | | | | | төг | % |
| Хонины мах, ястай | 7495 | 6675 | 7040 | +365 | 5.18 | 7105 | 7145 | 7145 | 7635 | 7530 | -105 | 1.4 |
| Үхрийн мах, ястай | 8380 | 7775 | 8425 | +650 | 7.7 | 8450 | 8480 | 8480 | 8555 | 8220 | -335 | 3.9 |
| Үхрийн мах, цул | 9890 | 9615 | 9970 | +355 | 3.6 | 9990 | 10040 | 9985 | 10335 | 10335 | - | - |
| Адууны мах, ястай | 6630 | 6475 | 6545 | +70 | 1.07 | 6550 | 6550 | 6550 | 6550 | | | |
| Ямааны мах, ястай | 5680 | 5560 | 5720 | +160 | 2.8 | 5775 | 5775 | 5775 | 5775 | | | |

- Эх үүсвэр: Үндэсний статистик хорооны цахим сайт: www.nso.mn

**Махны үнийг харьцуулсан график (2011-2014 он, сараар)**




| | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2011 он | 4203 | 4250 | 3810 | 3607 | 4101 | 4086 | 4209 | 4253 | 4322 | 4135 | 4093 | 4404 |
| 2012 он | 4986 | 6116 | 7025 | 7016 | 7188 | 7174 | 7462 | 7198 | 6912 | 6232 | 6133 | 6247 |
| 2013 он | 6914. | 7185 | 7435 | 8022. | 8465. | 8346. | 8079 | 7495. | 7161. | 6768. | 6550 | 6962. |
| 2014 он | 7477 | 6675 | 7,040 | | | | | | | | | |

- Хонины ястай махны үнэ: 2014 оны 3 дугаар сарыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,3%-ийн бууралттай байна.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР 2014 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БОЛОН ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БЭЛТГЭЖ БАЙГАА АСУУДЛЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Хэлэлцүүлэх асуудлын агуулга | Төлөвлөсөн огноо | Хэрэгжилт | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | Хэлэлцүүлсэн огноо | Шийдвэрийн дугаар | |
| 1. | Улсын сайн малчин, улсын тэргүүний малчдын бүлэг, улсын тэргүүний фермер шалгаруулах тухай | 2014.01.25 | 2014.01.11 | Дугаар 6 | |
| 2. | Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөрийн тайлангийн танилцуулга | 2014.01.25 | 2013.12 | 58 тэмдэглэл | |
| 3. | Төмс, хүнсний ногоо хөтөлбөрийн төсөл | 2014.02.15 | | | “Газар тариалангийн тогтвортой хөгжил хөтөлбөр” нэрээр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. |
| 4. | Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл | 2014.02.22 | | | Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж хуулийн үзэл баримтлалыг 2013.11.20 өдөр батлуулсан. Яамдаас саналыг тусгах асуудлыг хойшуулаад байна. |
| 5. | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл | 2014.02.22 | | | Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар 2013 оны 12 дугаар сарын 25-ны 01/5083 дугаар албан бичгээр Хууль зүйн сайдад хүргүүлж, 2014 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр батлуулсан. Хуулийн төслийг 2013 оны 11, 12 дугаар сард Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлсэн бөгөөд Яамдаас санал авч Засгийн газарт хүргэх бэлтгэл хангаж байна. |
| 6. | Зарим төрийн өмчит компанийг өөрчлөн байгуулах тухай /”Хөрс агрохимийн улсын төв лаборатори”, “Борнуур сорт сорилтын төв”, “Номгон сорт сорилт”, “Найрамдал сорт сорилт” болон “Алтан гангазга” төрийн өмчит үйлдвэрийн | 2014.03.01 | | | Сорт сорилын төвийг өөрчлөн зохион байгуулах тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан, яамдаас саналыг тусган, ЗГ-ын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | газар/ | | | | хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна |
| 7. | Малчдын хоршооны мастер төлөвлөгөөний төсөл | 2014.03.01 | | | ТНБДарга, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлэн болоод байна. ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэх нь хойшлогдоод байна. |
| 8. | Органик хүнсний тухай хуулийн төсөл | 2014.03.01 | | | Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль зүйн яаманд хүргүүлж, бүртгүүлсний дараа дахин сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.<br>Хэлэлцүүлсний үр дүнд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. |
| 9. | Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төсөл | 2014.03.01 | | | Сайдын зөвлөлийн хурлаар Органик хүнсний тухай хуулийг хэлэлцсэний дараа хэлэлцэхээр шийдвэрлэсэн. |
| 10. | Мал аж ахуйн хаваржилтийн нөхцөл байдлын талаар танилцуулга | 2014.03.22 | | | Хугацаа болоогүй |
| 11. | Стратегийн хүнсийг экспортлох, импортлоход зөвшөөрөл олгох түр журамд нэмэлт өөрчлөлт оруулах | 2014.03.29 | | | Сайдын зөвлөлийн хурлаар 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хэлэлцүүлж, яамдуудаас санал авч нэгтгэн, Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа засгийн газрын хуралдаанаар II улиралд багтаан хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. |
| 12. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | 2014.03.29 | | | Паркийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын саналыг хуулийн төсөлд тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байна. Хэлэлцүүлэгээр оруулсан саналыг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | тусган II улиралд ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлнэ. |
| 13. | Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх/ | 2014.03.29 | 2014.3.14 | 10 дугаар тэмдэглэл | Ажлын явцыг дараагийн ЗГ-ын хуралдаанд танилцуулсны дараа хэлэлцэхээр тогтов. |
| 14. | Монголд хүрээлэн буй орчинд ээлтэй тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх хөтөлбөрийн төсөл | 2014.03.29 | | | Сайдын зөвлөлийн 4 сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсний дараа ЗГ-ын хуралдаанд оруулна. |
| 15. | Дархан Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордын ашиглалтын асуудал болон зарим ордын эзэмшлийн талаар авах арга хэмжээний тухай | 2014.03.29 | | | УИХ-ыг гишүүн Б.Гарамгайбаатарын санаачилсан Төрөөс хүнд үйлдвэрийн талаар баримтлах бодлогын бичиг баримтыг УИХ-аар хэлэлцэхтэй холбоотойгоор хойшлогдсон байна. |

САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Хуралдаанаар хэлэлцсэн асуудал | Асуудал хэлэлцүүлсэн газар |
|---|---|---|
| 1. | Органик хүнсний тухай хууль | Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар |
| 2. | Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам-д нэмэлт өөрчлөлт оруулах | Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар |
| 3. | Фармакопейн хорооны ажиллах журам, бүрэлдэхүүн батлах | Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар |

................oOo..................